

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

### Товчилсон үгийн жагсаалт

МУ	Монгол Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
УБ	Улаанбаатар
ЗГ	Засгийн газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЗТХС	Зам, тээврийн хөгжлийн сайд
ИНЕГ	Иргэний нисэхийн ерөнхий газар
ОУНБ	Олон Улсын нисэх буудал
ТУЗ	Төлөөлөн Удирдах зөвлөл
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТБОНӨХБАУХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, үйлчилгээ худалдан авах тухай хууль, үйлчилгээ худалдан авах тухай
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар

## 1. Агуулга

1. Агуулга.....	2
2. Аудитын гэрчилгээ .....	3
2. Аудитын тайлан .....	5
2.1. Оршил .....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	7
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	7
2.9. Зорилтот түвшний гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	9
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	10
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	12
2.13. Шилэн дансны мэдээлэл.....	12
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	12
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	12
3. Менежментийн захидал.....	14
4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан .....	17
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан .....	17
4.2 Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	19
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	20
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	22
4.5 Аудит хийгдсэн зорилтот түвшний гүйцэтгэлийн тайлан .....	23
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	25



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

МИАТ ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ Д.БАТТӨР ТАНАА

2020.03.16 № 06/886  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу МИАТ ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

МИАТ ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль, тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар "МИАТ" ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

“МИАТ” ТӨХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

“МИАТ” ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Гүйцэтгэх захирал Д.Баттөр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, батлагдсан төсвийн дагуу зардал гаргах, хөрөнгийг санхүүгийн тайланд бүртгэх зэрэг зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “МИАТ” ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

“МИАТ” ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /НББОУС/, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/ түүнд нийцүүлэн гаргасан аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

“МИАТ” ТӨХК санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон НББОУС, СТОУС түүнд нийцүүлэн гаргасан аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 15-наас 2020 оны 03 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 17-ны өдөр эцэслэн баталгаажуулж, “МИАТ” ТӨХК-нд хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Р.Цолмон, гэрээт аудитор Б.Мөнгөнцэцэг, туслан гүйцэтгэгч “Сүлд аудит” ХХК нар хариуцаж хэрэгжүүлэв.

“МИАТ” ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан, тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 01/328 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

## 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

“МИАТ” ТӨХК-ийн үйл ажиллагааны үндсэн зорилт нь Нисэхийн аюулгүй ажиллагааны шаардлага стандартыг чандлан мөрдөж, үйлчилгээг тогтмол чанартай, найдвартай гүйцэтгэж, өрсөлдөх чадвартай, хүлээн зөвшөөрөгдсөн Монгол улсын үндэсний агаарын тээвэрлэгч компани байхад оршино.

Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл нь олон улсын болон орон нутгийн шугамын үйлчилгээнд иргэний тогтмол болон тогтмол бус нислэг үйлдэх явдал бөгөөд үйл ажиллагааны үндсэн чиглэлдээ нийцүүлэн хууль тогтоомжоор хориглоогүй, орлого, ашгаа нэмэгдүүлэхэд чиглэгдсэн бизнесийн бусад үйл ажиллагаа эрхэлж болно.

Компанийн эрхэмлэх зүйлс нь:

- Хаана ч, хэзээ ч нисэхийн аюулгүй ажиллагаа тэргүүнд байх;
- Агаарын хөлгийн осол гаргахгүй байх;
- Тогтвортой хөгжлийг эрхэмлэдэг байх;
- Зорчигч, үйлчлүүлэгчийн ая тух, санал хүсэлтийг эрхэмлэн дээдлэх ёс суртахуунтай байх;
- Нээлттэй, шударга харилцаа холбоог тогтоон багаар ажиллах чадвартай байх;
- Ажилтнуудынхаа туршлага, мэдлэг, ур чадварыг байнга дээшлүүлдэг байх;

Компанийн хэмжээнд харилцаа, мэдээллийн болон гүйцэтгэлийн асуудлыг цаг хугацаанд биелүүлэх соёлыг хэвшүүлдэг байх гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүү болон үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗТХС-ын 2019 оны 17, 27 дугаар тушаалуудаар БНХАУ-ын Шанхай, Гуанжоу хотын чиглэлд нислэгийн шугам хуваарилах, агаарын тээвэрлэгчийг томилсон;
- ТӨБЗГ-ын 584 дугаар тогтоолоор “МИАТ” ТӨХК-ийн 2019 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан;
- “МИАТ” ТӨХК-ийн ТУЗ болон Захирлын зөвлөлийн шийдвэрийн дагуу “Air Lease Corporation” компаниас 2021 онд үйл ажиллагааны түрээсээр авч ашиглах “Боинг 787-9” маркийн агаарын хөлгийн гэрээ байгуулсан;
- “МИАТ” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2019 оны А/732 дугаар тушаалаар Улаанбаатар-Хонгконг, Хонгконг-Улаанбаатар чиглэлийн зорчигчийн урамшуулалт тарифыг, дээрх чиглэлүүдэд энгийн зэрэглэлээр зорчих зорчигчдод үнэгүй тээвэрлэх тээшний ширхгийг 2 болгон тус тус баталсан;
- “МИАТ” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2019 оны А/753 дугаар тушаалаар Сөүл чиглэлийн зах зээлд нислэгийн тоо нэмэгдсэн, шинэ эйрлайнс нислэг үйлдэж эхэлсэнтэй холбогдуулан тухайн зах зээл дэх зорчигч урсгалыг нэмэгдүүлэх, суудал ашиглалтыг сайжруулах зорилгоор УБ-Сөүл-УБ, Сөүл-УБ-Сөүл чиглэлүүдэд урамшуулалт тариф баталсан;
- “МИАТ” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2019 оны А/791 дүгээр тушаалаар УБ-Сөүл-УБ чиглэлийн суудал ашиглалтыг сайжруулах зорилгоор өвлийн цагийн хуваарьт мөрдөх хөнгөлөлттэй тарифыг, дээрх чиглэлүүдэд зорчих зорчигчдод үнэгүй тээвэрлэх тээшний ширхгийг 2 болгон тус тус урамшууллыг баталсан;
- “МИАТ” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2019 оны А/866 дугаар тушаалаар Хонгконг чиглэлийн зах зээлийг идэвхжүүлэх, зорчигч урсгалыг нэмэгдүүлэх зорилгоор УБ-Хонгконг-УБ чиглэлийн зорчигчийн гэр бүл, тусгай тарифын урамшууллыг, Бангкокоос эхлэлтэй зорчигч урсгалыг татах зорилгоор Бангкок-УБ-Бангкок чиглэлийн групп тарифыг тус тус баталсан;
- МИАТ аппликэйшнийг зах зээлд нэвтрүүлж, тусгай үйлчилгээний Гэрэгэ картыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлсэн;
- Тийз борлуулалтын салбарууд нэмэгдсэн;
- Амадеус Altea системийн төслийн гүйцэтгэл 96.0 хувьд хүрсэн.

## 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус “МИАТ” ТӨХК-ийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцээгүй байна.

“МИАТ” ТӨХК нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Navision” программ хангамж ашигладаг байна.

“МИАТ” ТӨХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

## 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар “МИАТ” ТӨХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 34 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зарлагыг сонгож, эрсдэлийн түвшинг бага гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 455,329.6 сая төгрөгөөс тооцон 9,106.6 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг дахин тооцоолоогүй болно.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

“МИАТ” ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,042.6 сая төгрөгөөр буюу 1.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, богино хугацаат өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо данс байна.

### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	16,758.4	11,919.8	(4,838.6)
Бусад санхүүгийн хөрөнгө	42,170.6	34,147.4	(8,023.2)
Авлага	33,951.5	29,917.2	(4,034.3)
Урьдчилгаа	13,721.0	14,359.4	638.4
Бараа материал	32,945.6	42,596.1	9,650.5
Үндсэн хөрөнгө	140,991.9	136,311.5	(4,680.4)
Биет бус хөрөнгө	12,167.0	11,705.8	(461.2)

/сая төгрөг/

Бусад эргэлтийн бус хөрөнгө	31,940.6	37,646.9	5,706.3
<b>Нийт хөрөнгө</b>	<b>324,646.6</b>	<b>318,604.1</b>	<b>(6,042.5)</b>
Богино хугацаат өр төлбөр	124,913.2	133,746.7	8,833.4
Урт хугацаат өр төлбөр	146,799.1	104,414.4	(42,384.7)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	52,934.3	80,443.0	27,508.7
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>324,646.6</b>	<b>318,604.1</b>	<b>(6,042.5)</b>

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 11,919.8 сая төгрөг болж 4,838.6 сая төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны эцэст зорчигч урсгалын тоо буурснаар мөнгөн хөрөнгө багассан байна. Энэ нь зуны нислэгийн оргил ачааллын үед мөнгөн хөрөнгийн урсгал нэмэгдэж, тайлант хугацааны эцэст агаарын хөлгийн зээлийн төлөлт их хэмжээгээр төлөгдөж байгаатай холбоотой байна.

Бусад санхүүгийн хөрөнгө дансанд тайлант оны эцэст арилжааны 5 банканд хадгаламж хэлбэрээр байршиж байгаа нийт 34,147.4 сая төгрөгийн мөнгөн хөрөнгө байна.

Авлага дансны үлдэгдэл 29,917.1 сая төгрөг болж 4,034.4 сая төгрөгөөр буурсан нь дансны авлага 4,609.5 сая төгрөгөөр, дотоод тооцооны авлага 128.1 сая, хүүгийн авлага 270.9 сая төгрөгөөр тус тус буурснаас шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэлд 2008-2016 онуудад үүссэн 2,781.1 сая төгрөгийн 47 байгууллага болон хувь хүнээс барагдах боломжгүй, эрсдэлтэй авлага байна.

Бусад авлага тайлант оны эхэнд 2,002.7 сая төгрөг, тайлант хугацааны эцэст 2,056.8 сая төгрөг болж 54.1 сая төгрөгөөр өссөн. Үүнд ажилчдаас авах авлага 67.0 хувь буюу 1,373.8 сая төгрөг, дараа сард баталгаажих хэрэгжээгүй НӨАТ 21.0 хувь буюу 424.3 сая төгрөг, Хадгаламжийн хүүгийн авлага 8.0 хувь буюу 161.5 сая төгрөг, шүүхийн шийдвэрийн дагуу харилцагчаас авах 97.1 сая төгрөгийн авлага тус тус байна.

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэлд 8,585.5 сая төгрөгийн Wells Fargo Bank Northwest, National Association банкнаас авсан зээлд байршуулсан урьдчилгаа, 3,432.8 сая төгрөгийн Агаарын хөлгийн сэлбэг тээвэрлэлтийн урьдчилгаа, агаарын хөлгийн даатгал, нисэх бүрэлдэхүүний амь насны даатгалын урьдчилгаа, 1,321.0 сая төгрөгийн агаарын хөлгийн сэлбэг захиалгын урьдчилгаа болон ажилтан албан хаагчидтай дараа тооцоогоор үүссэн урьдчилгаа байна.

Бараа материалын данс нь 9,650.5 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байгаа нь тайлант хугацаанд худалдан авалтын төлөвлөгөөний дагуу 171,195.8 сая төгрөгийн худалдан авалт хийж, 161,545.3 сая төгрөгийн зарцуулсан байна.

Худалдан авсан бараа материалын 171,195.8 сая төгрөгөөс 4.9 хувь буюу 8,482.6 сая төгрөг нь онгоцны сэлбэг болон багаж хэрэгслүүд байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 136,311.5 сая төгрөг болж 4,680.4 сая төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд байгуулсан үндсэн хөрөнгийн элэгдэл болон балансаас балансад шилжүүлсэн хөрөнгө болон акталснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө ТӨБЗГ-ын 2019 оны 27, 187, 188, 310 дугаар тогтоолуудаар Буянт ухаа боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын алба, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Хүнс, хөдөө, ахуй хөнгөн үйлдвэрийн яам, Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ, Дархан АЗЗА, Налайх АЗЗА, Дорноговь АЗЗА, Увс АЗЗА, Говь-Алтай АЗЗА, Сэлэнгэ АЗЗА ТӨХК-уудад 616.2 сая төгрөгийн үнэ төлбөргүй шилжүүлсэн хөрөнгө, ТӨБЗГ-ын 2019 оны 318 дугаар тогтоолоор акталсан 109.4 сая төгрөгийн хөрөнгөөр тус тус хасагдсан байна.

Биет бус хөрөнгө тайлант хугацаанд 102.7 сая төгрөгөөр нэмэгдсэн нь бизнес төлөвлөлтийн болон агаарын хөлгийн /software disk/ программ хангамж худалдан авсан,

563.8 сая төгрөгийн хорогдуулгын дүнгээр хасагдаж тайлант хугацааны эцэст 11,705.8 сая төгрөг болсон байна.

Бусад эргэлтийн бус хөрөнгө дансанд агаарын хөлгүүдийн барьцааг бүртгэдэг бөгөөд тайлант оны эхэнд 31,940.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан бол тайлант хугацааны эцэст 37,646.9 сая төгрөг болж 5,706.3 сая төгрөгөөр нэмэгдсэн.

Бусад эргэлтийн бус хөрөнгө дансны эцсийн үлдэгдэлд 81.4 хувь нь буюу 30,659.7 сая төгрөг агаарын хөлөг түрээслэгч 7 харилцагчтай холбоотой бол 18.6 хувь нь буюу 6,987.3 сая төгрөг нь агаарын хөлөг худалдан авахтай холбоотой Wells Fargo Bank Northwest, National Association банкинд байршуулсан барьцаа эзэлж байна.

Агаарын хөлөг шинээр түрээслэх гэрээ байгуулсантай холбоотой Avolon aerospace leasing limited компанид 10,296.8 сая төгрөг, ALC UK Aircraft limited компанид 4,647.0 сая төгрөг, FTAI AirOpCo UK limited компанид 1,763.1 сая төгрөгийн барьцааг тус тус байршуулсантай холбоотойгоор дансны үлдэгдэл өссөн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 238,161.1 сая төгрөг болж 33,551.3 сая төгрөгөөр буурсан нь богино хугацаат өр төлбөр 8,833.4 сая төгрөгөөр нэмэгдэж, урт хугацаат өр төлбөрийн данс 42,384.7 сая төгрөгөөр тус тус буурснаас шалтгаалжээ.

Богино хугацаат өр төлбөрийн данс нийт 8,833.4 сая төгрөгөөр өссөн нь 2018 оны ногдол ашгийн өглөгийг төлж барагдуулаагүйгээс 7,335.1 сая, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын өглөг 1,474.6 сая төгрөгөөр, банкны зээлийн төлөлтийн валютын ханшийн өөрчлөлтөөс 1,670.3 сая төгрөгөөр, дансны өглөг 939.4 сая төгрөгөөр, цалин болон ХАОАТ-ын өглөг 371.9 сая төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Богино хугацаат өр төлбөрийн дансанд банкны зээл 48,475.3 сая төгрөг, дансны өглөг 31,602.6 сая, урьдчилж орсон орлого 30,547.7 сая, татварын өр 12,547.3 сая, ногдол ашгийн өглөг 7,335.1 сая төгрөгийн өглөгүүд нь нийт богино хугацаат өр төлбөр дансны 97.9 хувийг эзэлж байна.

Урт хугацаат өр төлбөрийн данс тайлант хугацаанд нийт 42,384.7 сая төгрөгөөр буурсан нь урт хугацаат банкны зээлийн өр 43,374.7 сая төгрөгөөр буурч, агентуудын барьцааны өглөг 989.9 сая төгрөгөөр өссөн байна.

Урт хугацаат өр төлбөрийн дансанд нийт 104,414.4 сая төгрөгийн өр байгаагаас 2013 онд агаарын хөлөг худалдан авахтай холбоотой Хөгжлийн банк, Голомт, Хас банкууд болон Private Export Funding Corporation, ING Capital LLC банкнуудаас авсан зээлийн өр 99,820.5 сая төгрөг, барьцаат өглөг 4,593.9 сая төгрөг байна.

Эзэмшигчийн өмчийн дансны үлдэгдэл 80,443.0 сая төгрөг болж 27,508.7 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд 35,289.6 сая төгрөгийн ашигтай ажилласнаас шалтгаалжээ.

## 2.9. Зорилтот түвшний гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3<sup>1</sup>, 6<sup>2</sup>-д заасны дагуу Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны 584 дүгээр тогтоолоор “МИАТ” ТӨХК-ийн 2019 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант онд 491,386.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 470,271.4 сая төгрөгийн зардалтай, 21,115.3 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай байхаар батлагджээ.

<sup>1</sup> Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3-т “төрийн өмчит хуулийн этгээдээс дагаж мөрдөх төлөвлөлт, ашиг орлогын хуваарилалтыг холбогдох байгууллагатай тохиролцон тогтоох”,

<sup>2</sup> Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6-д “төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөгчийг томилж, түүний үйл ажиллагаанд хяналт тавих” гэж тус тус заасан байна.

*Хүснэгт 2. 2019 оны нислэг тээвэрлэлтийн зорилтот түвшин, түүний гүйцэтгэл*

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2019 он		Өөрчлөлт	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Тоо	Хувь
Зорчигч тээвэрлэлт	мян.хүн	767.8	789.3	21.5	103.0
Ачаа тээвэрлэлт	тонн	3,750.6	2,990.9	(759.7)	80.0

Зорчигч тээвэрлэлтийн тоо төлөвлөгөөнөөс 21.5 мянган хүнээр буюу 2.8 хувиар, өмнөх оноос 69.7 мянган хүнээр буюу 9.7 хувиар тус тус нэмэгдэж, ачаа тээвэрлэлт батлагдсан төлөвлөгөөнөөс 759.7 тонн буюу 20.3 хувиар, өмнөх оноос 59.8 тонн буюу 2.0 хувиар тус тус буурсан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 459,935.4 сая төгрөг батлагдсанаас 450,763.9 сая төгрөг бүрдүүлж, 9,171.5 сая төгрөгөөр тасарсан нь агаарын тээврийн зах зээлд гадаад болон дотоод өрсөлдөөн нэмэгдэж Улаанбаатар-Сөүл-Улаанбаатар чиглэлд Asiana airlines, Улаанбаатар-Хонг Конг-Улаанбаатар чиглэлд Изинис Эйрвэйз ХХК шинээр нэмэгдэж, Улаанбаатар-Москва-Улаанбаатар чиглэлд Аэрофлот компани агаарын хөлгөө томруулж зорчигч урсгалыг хувааснаас өндөр тарифтай тийзийн борлуулалт буурч, хямд тарифтай тийзийн борлуулалт өссөнөөс шалтгаалсан байна.

Үндсэн бус үйл ажиллагааны орлого 30,251.2 сая төгрөг батлагдсанаас 34,991.5 сая төгрөг бүрдүүлж, 4,740.3 сая төгрөгөөр давсан нь Газрын үйл ажиллагааны орлого 17,926.2 сая төгрөг, Агаарын хөлгийн техник үйлчилгээний орлого 8,070.2 сая төгрөг, билет борлуулалттай холбоотой /өдөр солих, ангилал солих, чиглэл солих/ 4,972.6 сая төгрөг, онгоцон доторх борлуулалт, даатгалын нөхөн олговор, бизнес лонжийн орлого зэргээс 4,015.3 сая төгрөгийн орлого тус тус олсон байна.

Үйл ажиллагааны бус орлого 1,200.0 сая төгрөг батлагдсанаас 4,864.0 сая төгрөг бүрдүүлж, 3,664.0 сая төгрөгөөр давсан нь хадгаламжийн хүүгийн орлогоос 4,518.2 сая, Төрийн өмчийн түрээсийн 333.8 сая төгрөгийн орлого олсонтой холбоотой байна.

Нийт зардал 443,598.6 сая төгрөг болж, 26,672.8 сая төгрөгөөр дутуу буюу 94.3 хувийн гүйцэтгэлтэй байна.

Тайлант оны гүйцэтгэлээр татварын өмнөх ашиг төлөвлөсөн хэмжээнээс 25,905.5 сая төгрөгөөр нэмэгдэхэд үндсэн бус үйл ажиллагааны орлого төлөвлөгөөнөөс ойролцоогоор 3 дахин буюу 11,492.3 сая төгрөгөөр, зорчигчийн тоо 21.5 мянгаар нэмэгдсэнээс тус тус шалтгаалжээ.

**2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 14 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 17 эрсдэл тодорхойлж нийт 42 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 67,048.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 58,188.1 сая төгрөгийн алдааг залруулж, 70.3 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 1,258.1 сая төгрөгийн зөрчилд 6 албан шаардлага хүргүүлж, 7,531.8 сая төгрөгийн алдаа, зөрчилд 24 зөвлөмж өглөө. Үүнд:

1."МИАТ" ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайлангийн тодруулга тайлан санхүүгийн байдлын тайлангаас нийт 58,188.1 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн нь Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавартай нийцээгүй, үнэн зөв, байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулав.

2.Тайлант хугацааны санхүүгийн тайлангаар Засгийн газрын нөөц сангаас авсан зээлийн алданги 989.8 сая төгрөгийг төлөөгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх.

3. "МИАТ" ТӨХК нь "Нүхт-Тур" ХХК-тай 2009 оноос эхлэн 09/131 дугаартай "МИАТ" ТӨХК-ийн катерингийн төвийн удирдах үйл ажиллагааг гүйцэтгэх удирдлагын гэрээг байгуулан хамтран ажиллаж эхэлсэн байна. Тус гэрээний 2 дугаар зүйлийн 2.1.3-т "Гэрээг хоёр жилийн хугацаатайгаар хоёр удаа сунгаж болно" гэж заасан боловч түүнээс хойш нийт 7 удаа тус гэрээг сунгаж, хамгийн сүүлд 2019 оны 02 дугаар сараас 2020 оны 2 дугаар сар хүртэл дахин нэг жилээр сунган ажил, үйлчилгээг явуулжээ.

Гэтэл ЗТХЯ-ны 09/1137 дугаар албан бичигт тус сонгон шалгаруулалтыг "Улаанбаатар хотын Олон Улсын нисэх онгоцны шинэ буудлыг ашиглалтад оруулах хугацаатай зайлшгүй уялдуулалгүйгээр, нислэг үйлдвэрлэлийн үйл ажиллагааг тогтвортой хангахаар зохион байгуулах нь зүйтэй гэснийг баримтлан ажиллах шаардлагатай байна" гэсэн чиглэлийг баримтлан ажиллахаар "МИАТ" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2019 оны 11 дүгээр сарын А/835 дугаар тушаалаар Хөшигийн хөндий дахь шинэ нисэхийн катерингийн үйлчилгээ үзүүлэх Үнэлгээний хороо байгуулсан боловч хэрэгжүүлээгүй байна. Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 8.1.1-д "Босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ", ЗГ-ын 2013 оны 68 дугаар тогтоолоор баталсан "Худалдан авах бараа 50.0 сая, ажил, үйлчилгээ 100.0 сая төгрөгийн босго үнээс дээш тохиолдолд тендер сонгон шалгаруулалт зарлан зохион байгуулах" гэсэн заалтуудтай нийцэхгүй, үнэн зөв байх, тохиолдсон байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх.

4. ТӨБЗГ-ын 2019 оны 380 дугаар тогтоолоор "МИАТ" ТӨХК-ийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тодотгол хийж, бага оврын технологийн автомашиныг 30.0 сая, суудлын автомашиныг 35.0 сая төгрөгөөр тус тус худалдаж авахаар тусгажээ. Гэвч тус 2 автомашиныг худалдаж авахдаа харьцуулалтын аргаар тендер шалгаруулалтыг зохион байгуулаагүй, дээрх хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний тодотгол батлагдахаас 2 сарын өмнө хувь хүнээс 65.0 сая төгрөгөөр автомашинуудыг худалдан авсан байна. Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д "Харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар", ЗГ-ын 2013 оны Босго үнэ шинэчлэн батлах тухай 68 дугаар тогтоолын заалтуудтай нийцэхгүй, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх.

5."Хүлэгтхүннү аудит" ХХК-тай 2017 оны 3-17/01 дугаар Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 44.0 сая төгрөгөөр шинэчлэн боловсруулах гэрээ хийсэн ч 2017 оны жилийн эцсийн байдлаар ажлыг дуусгаагүй, хүлээлгэж өгөөгүй, гэрээний 3 дугаар зүйлийн 3.2.5.1-д "Гэрээнд заасан хугацаанд ажлыг хүлээлгэж өгч чадаагүй бол хугацаа хэтэрсэн хоног дутамд гүйцэтгээгүй үүргийн дүнгийн 0.5 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг үйлчлүүлэгч талд төлөх үүрэгтэй" гэж заасан боловч 17.0 сая төгрөгийн алдангийг тооцож аваагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", 20 дугаар зүйлийн 20.2.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах,

батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах” гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

6. Тайлант хугацааны эцэст 14.2 сая төгрөгийн шууд бус орлого болох хоол, унааны мөнгийг хөнгөлөлт эдлэх орлогод оруулан татвар тооцоогүй нь ХХОАТ-ын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал дээр ажил олгогчоос нэмж олгож байгаа тухайн ажилтнаас албан үүргээ гүйцэтгэхэд шууд холбогдолгүй дараах бараа, үйлчилгээний орлогыг албан татвар ногдох шууд бус орлогод хамруулна”, 15 дугаар зүйлийн 15.1.3-т “бэлнээр олгосон хоолны мөнгө, түүнчлэн үзвэр үйлчилгээний олговор” гэсэн заалтуудтай нийцэхгүй, үнэн зөв байдал, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

Залруулагдаагүй 6,658.3 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

“МИАТ” ТӨХК-ийн харьяа 5 Төлөөлөгчийн газарт хийсэн завсарын аудитаар нийт 1,115.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 39.1 сая төгрөгийн акт, 203.3 сая төгрөгийн албан шаардлага, 873.5 сая төгрөгийн зөвлөмж өгч асуудлын бүртгэлээр баталгаажуулав.

## **2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Зорилтот түвшний гүйцэтгэлээр 490,619.4 сая төгрөгийн орлоготой 443,598.6 сая төгрөгийн зардал гаргаж, 35,289.7 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Дараагийн аудитаар ТУЗ-ын тогтоол, шийдвэрийн биелэлт, мөнгөн хөрөнгийн хадгаламж, авлага, өглөгийн баталгаажуулалт, хугацаа хэтэрсэн авлага, бараа материалын худалдан авалт болон бараа материалын үлдэгдэл, цалингийн зардал, ажиллагсдад олгосон зээл, сургалтын зардал, Бойнг МАХ агаарын хөлгийн нислэгийг зогсоосонтой холбоотой зардал, авлага барагдуулалтад нарийвчилсан горим сорил гүйцэтгэнэ.

## **2.13. Шилэн дансны мэдээлэл**

“МИАТ” ТӨХК Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 60 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

## **2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 3,685.8 сая төгрөгийн 1 албан шаардлага, 1 зөвлөмж өгснөөс хэрэгжилт 50.0 хувьтай байна.

## **2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид “МИАТ” ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Залруулагдаагүй 8,860.2 сая төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон 9,106.6 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул зөрчилгүй дүгнэлт өгч байна.

“МИАТ” ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн залруулагдаагүй буруу илэрхийллийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөөг эс тооцвол 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, СТОУС-ын дагуу

материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой тусгав.

### **3. Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **1. Өглөгийн данстай холбоотой асуудал**

##### **1.1 Илрүүлэлт:**

Тайлант хугацааны санхүүгийн тайлангаар 2011-2015 онуудад үүссэн ИНЕГ-ын 2,106.6 сая төгрөгийн новигацийн төлбөр, Чингис хаан ОУНБ-д 4,439.5 сая төгрөгийн буулт, хөөрөлт, бүртгэх цэг, онгоцны зогсоолын болон каргоны төлбөр төлөх нийт 6,546.1 сая төгрөгийн үйлчилгээний төлбөрийг төлөөгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

##### **1.2 Эрсдэл:**

Өр төлбөр барагдуулаагүйгээс байгууллагын төлбөрийн чадвар сөргөөр илэрхийлэгдэх.

##### **1.3 Өгсөн зөвлөмж:**

Хугацаа хэтэрсэн өглөгийг барагдуулах арга хэмжээ авах.

##### **1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

#### **2. Зардлын данстай холбоотой асуудал**

##### **2.1 Илрүүлэлт:**

Тайлант онд ажилтан албан хаагчдын 112.2 сая төгрөгийн албан томилолтын дараа тайлангийн тооцоог хийж баталгаажуулаагүйгээс тайлант оны зардлаар бүртгээгүй байна. Энэ нь Компанийн ажилтнуудын албан томилолтын зардлыг төлөвлөх, хянах, тайлан тооцоо хийх журмын 4 дүгээр зүйлийн 4.1-д "Албан томилолтын тооцоог ирсэн өдрөөс хойш ажлын 3-5 хоногт багтаан зарцуулсан зардлын баримтуудыг бүрдүүлэн хариуцсан нягтлан

бодогчтой тооцоо нийлж, үлдэгдэл мөнгийг тушаана" гэсэн заалтыг баримтлан ажиллаагүй байна.

**2.2 Эрсдэл:**

Зардал буруу илэрхийлэгдэх.

**2.3 Өгсөн зөвлөмж:**

Албан томилолтын дараа тайлангийн тооцоог тухай бүрд нь тооцож, зардалд тусгаж байх.

**2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

**3. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал**

**3.1 Илрүүлэлт:**

НБББББ-т борлуулсан бүтээгдэхүүний өртөгт нойтон түрээсийн нислэгийн зардал, нислэгийн багийн томилолт, гишүүнчлэлийн зардал, бизнес лоунж болон сувинер шопын өртөг, газрын үйлчилгээ, техник үйлчилгээний зардлуудыг тусгахаар заагаагүй байтал тайлант онд борлуулсан бүтээгдэхүүний өртөгт дээрх зардлуудыг шингээсэн байна.

**3.2 Эрсдэл:**

Борлуулсан бүтээгдэхүүний өртгийг буруу тооцоолсон байх.

**3.3 Өгсөн зөвлөмж:**

НБББББ-т борлуулсан бүтээгдэхүүний өртөгт шингээх зардлуудыг зөв тодорхойлж тусгах.

**3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

**4. Шатахууны худалдан авалтын талаар**

**4.1 Илрүүлэлт:**

Автомашин бензин, дизель түлшийг худалдан авах тендерт Сод Монгол Групп ХХК шалгарч гэрээ байгуулах эрх олгох тухай албан бичгийг 2019 оны 07 дугаар сарын 8-нд явуулсан боловч гэрээг 2019 оны 08 дугаар сарын 5-ны өдөр байгуулсан нь тендерийн хүчинтэй хугацаа /2019.07.01-2019.08.01/-нд хийгээгүй байна. Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5-д заасан "Тендер нээснээс хойш тухайн тендер шалгаруулалтыг 30 хоногт багтаан зохион байгуулж дуусгах бөгөөд уг хугацаанд тендер хүчинтэй байна", 29 дүгээр зүйлийн 29.2-г заасан "Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш ажлын 6-аас доош хоногийн дараа тендер хүчинтэй байх хугацаанд багтааж гэрээ байгуулна" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

**4.2 Эрсдэл:**

Гэрээг хугацаандаа хийгээгүйгээс төлөвлөсөн ажил хугацаандаа хийгдэхгүй байх.

**4.3 Өгсөн зөвлөмж:**

Тендерийг "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах тухай" хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5, 29 дүгээр зүйлийн 29.2-ыг тус тус баримтлан ажиллах.

*4.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:*

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12 сарын 31 өдөр	2019 оны 12 сарын 31 өдөр
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	16,758,428,179.16	11,919,839,762.07
1.1.2	Дансны авлага	30,477,124,981.67	25,723,061,106.08
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	1,471,667,754.89	2,137,307,648.84
1.1.4	Бусад авлага	2,002,703,197.88	2,056,771,164.16
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	42,170,597,111.29	34,147,418,026.32
1.1.6	Бараа материал	32,945,578,369.01	42,596,129,965.43
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	13,720,997,845.04	14,359,380,935.84
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>139,547,097,438.94</b>	<b>132,939,908,608.74</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	140,991,861,506.54	136,311,459,945.03
1.2.2	Биет бус хөрөнгө	12,167,041,119.98	11,705,849,888.86
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	31,940,613,771.23	37,646,854,781.02
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>185,099,516,397.75</b>	<b>185,664,164,614.91</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>324,646,613,836.69</b>	<b>318,604,073,223.65</b>
<b>2</b>	<b>Өр төлбөр ба эздийн өмч</b>		
<b>2.1</b>	<b>ӨР ТӨЛБӨР</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	30,663,158,652.73	31,602,581,755.81
